**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/134/-НА-СТА-ТШ3


Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас:70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудитор:

Утас: 70484055 Цахим хаяг: govialtai@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Говь-Алтай аймаг

Алтай хот

2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл........................................ 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/........................................ 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөг/........................................ 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөг/........................................ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөг/........................................ 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/........................................ 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/ ...........**Error! Bookmark not defined.**
3. Аудитын тайлан........................................ 9
3.1 Ерөнхий зүйл........................................ 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........................................ 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал........................................ 10
3.4 Материаллаг байдал........................................ 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга........................................ 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв........................................ 10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................ 11
3.8 Аудитын гол асуудал........................................ 11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал........................................ 11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт........................................ 11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........................................ 12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал........................................ 12
4. Аудитын илрүүлэлт........................................ 12
4.1 Залруулсан алдаа........................................ 12
4.2 Албан шаардлага........................................ 12
4.4 Зөвлөмж........................................ 13
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........................................ 13

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E –mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 134

танай ______ -ны № ______ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ОТГОНБАЯР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07000348

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл  нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.ТҮВШИНБАЯР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 29,148,036.80 | 45,047,831.80 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 29,148,036.80 | 45,047,831.80 |
| 35100 | Түүхий эд материал | 14,190,682.80 | 28,790,682.80 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 14,190,682.80 | 28,270,682.80 |
| 35130 | Эм боох материал | 0.00 | 520,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 14,957,354.00 | 16,257,149.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 29,500.00 | 339,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,017,800.00 | 4,471,050.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,773,070.00 | 3,310,015.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,136,984.00 | 8,136,984.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 984,842,198.58 | 972,425,911.80 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 984,842,198.58 | 972,425,911.80 |
| 39200 | Биет хөрөнгө | 979,618,198.58 | 967,201,911.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 996,408,886.66 | 996,408,886.66 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (66,770,614.66) | (79,462,078.72) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 41,241,520.00 | 41,241,520.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,603,136.64) | (21,229,186.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33,625,965.59 | 40,625,965.59 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,162,343.86) | (12,793,996.34) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,943,233.00 | 12,943,233.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (10,773,211.51) | (11,240,331.85) |
| 39217 | Ном | 707,900.00 | 707,900.00 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 5,224,000.00 | 5,224,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,224,000.00 | 5,224,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,013,990,235.38 | 1,017,473,743.60 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,013,990,235.38 | 1,017,473,743.60 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,013,990,235.38 | 1,017,473,743.60 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 30,734,240.00 | 30,734,240.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 920,333,433.41 | 923,816,941.63 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 930,786,553.59 | 920,333,433.41 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (10,453,120.18) | 3,483,508.22 |
| 51230 | Давхардсан гүйлгээ цэвэрлэх данс | 0.00 | 0.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 62,922,561.97 | 62,922,561.97 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,013,990,235.38 | 1,017,473,743.60 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 305,885,300.00 | 282,224,950.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,753,500.00 | 20,310,550.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,753,500.00 | 479,150.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,753,500.00 | 479,150.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 0 | 0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,753,500.00 | 479,150.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0 | 19,831,400.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 0 | 10,070,600.00 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 0 | 7,000,000.00 |
| 123003 | Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг | 0 | 2,760,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 300,131,800.00 | 261,914,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 274,040,800.00 | 241,913,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 274,040,800.00 | 241,913,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,091,000.00 | 20,001,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,091,000.00 | 20,001,100.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 316,338,420.18 | 278,741,441.78 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 316,338,420.18 | 278,741,441.78 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 288,688,793.21 | 271,616,925.32 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 185,045,705.17 | 183,845,690.88 |
| 210101 | Үндсэн цалин | 168,738,648.62 | 168,228,449.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0 | 5,207.94 |
| 210104 | Урамшуулал | 16,307,056.55 | 15,612,033.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,320,845.70 | 24,484,995.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,871,886.62 | 17,461,551.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,867,057.05 | 1,406,453.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,490,445.63 | 1,492,139.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 365,342.30 | 376,724.26 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,726,114.10 | 3,748,127.04 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,778,262.16 | 24,786,146.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,029,786.16 | 1,178,211.83 |
| 210302 | Түлш, халаалт | 22,048,776.00 | 23,607,935.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,699,700.00 | 0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,931,770.00 | 5,380,650.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,002,450.00 | 640,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,531,920.00 | 4,185,650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 354,700.00 | 200,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 262,400.00 | 48,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 780,300.00 | 307,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 12,058,160.00 | 10,897,855.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 359,000.00 | 677,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,519,160.00 | 10,220,355.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 180,000.00 | 0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,098,000.00 | 515,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 90,000.00 | 515,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,008,000.00 | 0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 350,000.00 | 238,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 238,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0 | 0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 599,000.00 | 1,021,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0 | 373,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 275,000.00 | 0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,507,050.18 | 20,447,086.78 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 397,000.00 | 1,030,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 35,110,050.18 | 19,416,286.78 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,649,626.97 | 7,124,516.46 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,309,376.00 | 1,333,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,309,376.00 | 1,333,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0 | 5,791,516.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 5,791,516.46 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 304,737.84 | 0 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 304,737.84 | 0 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 26,035,513.13 | 0 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,035,513.13 | 0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (10,453,120.18) | 3,483,508.22 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (10,453,120.18) | 3,483,508.22 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 30,734,240.00 | 62,922,561.97 | 930,786,553.59 | 1,024,443,355.56 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 30,734,240.00 | 62,922,561.97 | 930,786,553.59 | 1,024,443,355.56 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 7 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 8 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (10,453,120.18) | (10,453,120.18) |
| 10 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 30,734,240.00 | 62,922,561.97 | 920,333,433.41 | 1,013,990,235.38 |
| 11 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 30,734,240.00 | 62,922,561.97 | 920,333,433.41 | 1,013,990,235.38 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 30,734,240.00 | 62,922,561.97 | 920,333,433.41 | 1,013,990,235.38 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 3,483,508.22 | 3,483,508.22 |
| 20 | 2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 30,734,240.00 | 62,922,561.97 | 923,816,941.63 | 1,017,473,743.60 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 300,131,800.00 | 274,745,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 0.00 | 10,576,563.29 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.00 | 10,576,563.29 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 0.00 | 10,576,563.29 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 300,131,800.00 | 264,169,236.71 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 274,040,800.00 | 244,168,136.71 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 274,040,800.00 | 244,168,136.71 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,091,000.00 | 20,001,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,091,000.00 | 20,001,100.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 282,113,860.00 | 274,745,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 282,113,860.00 | 274,745,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 254,464,233.03 | 267,621,283.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 185,045,705.17 | 183,845,690.88 |
| 210101 | Үндсэн цалин | 168,738,648.62 | 168,228,449.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 5,207.94 |
| 210104 | Урамшуулал | 16,307,056.55 | 15,612,033.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,320,845.70 | 24,484,995.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,871,886.62 | 18,079,957.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,867,057.05 | 930,277.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,490,445.63 | 1,405,876.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 365,342.30 | 351,028.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,726,114.10 | 3,717,856.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,778,262.16 | 24,786,146.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,029,786.16 | 1,178,211.83 |
| 210302 | Түлш, халаалт | 22,048,776.00 | 23,607,935.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,699,700.00 | 0.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,286,770.00 | 5,721,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,009,950.00 | 792,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,531,920.00 | 3,658,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 354,700.00 | 292,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 262,400.00 | 98,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,127,800.00 | 880,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 12,623,150.00 | 21,965,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 359,000.00 | 687,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,084,150.00 | 10,278,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 180,000.00 | 11,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,098,000.00 | 4,267,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 90,000.00 | 4,267,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,008,000.00 | 0.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 350,000.00 | 238,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 238,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 599,000.00 | 1,065,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 417,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 275,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 362,500.00 | 1,247,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 362,500.00 | 1,247,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,649,626.97 | 7,124,516.46 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,309,376.00 | 1,333,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,309,376.00 | 1,333,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 5,791,516.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 5,791,516.46 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 304,737.84 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 304,737.84 | 0.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 26,035,513.13 | 0.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 26,035,513.13 | 0.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 18,017,940.00 | 0.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 18,017,940.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 18,017,940.00 | 0.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 18,017,940.00 | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,017,940.00 | 0.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (18,017,940.00) | 0.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөг/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 274,745,800.00 | 268,954,283.54 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 274,745,800.00 | 268,954,283.54 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 273,385,800.00 | 267,621,283.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 185,831,800.00 | 183,845,690.88 |
| 210101 | Үндсэн цалин | 169,810,800.00 | 168,228,449.94 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0 | 5,207.94 |
| 210104 | Урамшуулал | 16,021,000.00 | 15,612,033.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,391,000.00 | 24,484,995.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,434,000.00 | 18,079,957.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,240,000.00 | 930,277.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,791,000.00 | 1,405,876.43 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 448,000.00 | 351,028.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,478,000.00 | 3,717,856.40 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,008,000.00 | 24,786,146.83 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,400,000.00 | 1,178,211.83 |
| 210302 | Түлш, халаалт | 23,608,000.00 | 23,607,935.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,760,000.00 | 5,721,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 792,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,660,000.00 | 3,658,250.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 292,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | 98,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 900,000.00 | 880,600.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,136,800.00 | 21,965,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 700,000.00 | 687,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,436,800.00 | 10,278,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,000,000.00 | 11,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,300,000.00 | 4,267,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,300,000.00 | 4,267,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 600,000.00 | 238,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,000.00 | 238,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,108,000.00 | 1,065,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 460,000.00 | 417,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 648,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,250,200.00 | 1,247,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,250,200.00 | 1,247,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,360,000.00 | 1,333,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,360,000.00 | 1,333,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,360,000.00 | 1,333,000.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 274,745,800.00 | 264,169,236.71 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 248,737,800.00 | 244,168,136.71 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 248,737,800.00 | 244,168,136.71 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 26,008,000.00 | 20,001,100.00 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 26,008,000.00 | 20,001,100.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, татварын байгууллагатай тооцоо нийлж санхүүгийн тайланг бодитой үнэн зөв хөтлөхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Улиастай ван аудит" ХХК-ийн аудитор П. Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 255.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 278.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.3 хувиар буюу 3.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлага данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45.1 сая төгрөг болж 15.9 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 32.9 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 17.0 сая төгрөгийн материалыг зарцуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1079.2 сая төгрөг болсон нь 7.0 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1017.5 сая төгрөг болж тайлант оны алдагдал 3.5 сая төгрөгөөр буурсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 278.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 278.5 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 252.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 269 сая төгрөгийг зарцуулж 7.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 269.0 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 5.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 0.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1.2 сая төгрөгөөр, норматив зардлыг 1.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд гүйлгээ гараагүй болно.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, и-баримтын бүрдэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Шилэн дансныхуулийн хэрэгжилтийг цахим цэснээс тулган баталгаажуулахад 352.0 сая төгрөгийн 95 мэдээллийг мэдээлэхээс 243.5 сая төгрөгийн 67 мэдээллийг бүрэн мэдээлж 109.0 сая төгрөгийн 28 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг нь өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хэрэгжүүлсэн бөгөөд албан бичиг нотлох баримтыг ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Дараагийн Дараагийн аудитаар Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт 26.3 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулга хийгээгүй болно.

### 4.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлан дахь татварын өглөг, авлага нь Татварын тодорхойлолтоос 682.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, шуудан холбооны зардал 25.6 сая төгрөгийг хоорондын тооцоо үүсгээгүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэль сууриар хөтөлнө. заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Батлагдсан төсвийн зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын"үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"гэж заасантай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг цахим цэснээс тулган баталгаажуулахад 352.0 сая төгрөгийн 95 мэдээллийг мэдээлэхээс 243.5 сая төгрөгийн 67 мэдээллийг бүрэн мэдээлж 109.0 сая төгрөгийн 28 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:, 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй болно.

## 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэг | 4 | 26.3 | - | - | - | - | 4 | 26.3 | - | - |
| | **НИЙТ** | 4 | 26.3 | - | - | - | - | **4** | **26.3** | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР